



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 1/41

Хараат

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “ШҮРЭН ТИТЭМ” ХХК-ны гүйцэтгэсэн “1 дүгээр багийн барилгын зураг төсөв”, “Наадмын талбайн тохижилтыг нэмэгдүүлэх зураг төсөв” – ийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Жаргалмаа (1 дүгээр багийн Засаг дарга)

Нарийн бичиг: Г.Эрдэнэтуяа (Архив, бичиг хэргийн эрлэгч)

Гишүүн: Б.Мөнхтогтох (ХАА-н мэргжилтэн)

2. Гүйцэтгэлийн чанар үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авсан акт үйлдэж баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцсэн акт холбогдох бичиг баримтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын өмчид бүртгэхийг нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4823000088